



СЭНД ЭМ ЭН ББСБ ХХК-ийн ТУЗ-ийн
ТӨЛӨӨ УДИРДАГ
ЗӨВЛӨГ 2025 оны 04 сарын 11 өдрийн
15/11 тогтоолын Хавсралт

**“СЭНД ЭМ ЭН ББСБ” ХХК-ИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛ (БОНЗ)-ЫН
БОДЛОГО**

2025 ОН



Баримт бичиг код:

SE/BD/01/POL/25.

Баримт бичиг нэр:

“Сэнд Эм Эн ББСБ” ХХК-ийн Байгаль орчин, нийгэм,
засаглал (БОНЗ)-ын бодлого

Хувилбар:

01

Хянасан огноо:

2025

Дараагийн үнэлгээ хийх огноо:

Ангилал:

Албан хэрэгцээнд

Хувилбар	Батлагдсан огноо, тушаалын дугаар	Өөрчлөлтийн тайлбар	Боловсруулсан	Хянасан
01		Анхны хувилбарыг боловсруулав	Дотоод аудит хариуцсан менежер Б.Намуундарь, Хөрөнгө удирдлагын менежер Э.Ариунзул	БОНЗ-ын төслийн баг, Гүйцэтгэх захирал Б.Төрболд

АГУУЛГА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

ХОЁР. БОНЗ-ЫН БОДЛОГЫН БАРИМТЛАХ ЗАРЧМУУД

ГУРАВ. БОНЗ-ЫН БОДЛОГЫН ЗАРЧМУУДЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГ ҮҮРЭГ

ДӨРӨВ. БУСАД

**“СЭНД ЭМ ЭН ББСБ” ХХК-ИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛ (БОНЗ)-ЫН
БОДЛОГО**

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү бодлогын зорилго нь “Сэнд Эм Эн ББСБ” ХХК (цаашид “Компани” гэх)-ийн байгаль орчин, нийгэм, засаглал (цаашид “БОНЗ” гэх)-ын тогтолцоог бий болгох, бизнесийн болон өдөр тутмын бүхий л үйл ажиллагаандаа байгаль орчин, нийгэмд ээлтэй, сайн засаглалын үйл ажиллагааг нэвтрүүлэх, тогтвортой хөгжил, ногоон эдийн засгийн өсөлтийг хангах чиг үүргийг биелүүлэхийн тулд баримтлах зарчмууд болон үүрэг хариуцлагыг тодорхойлоход оршино.
- 1.2. Энэхүү бодлогыг Компанийн урт дунд хугацааны бодлогын баримт бичиг болон бусад бодлогын баримт бичигтэй уялдуулан боловсруулав.

**Хоёр. Байгаль Орчин, Нийгэм, Засаглалын Бодлогын
баримтлах зарчмууд**

- 2.1. Компанийн БОНЗ-ын бодлого нь Монголын тогтвортой санхүүжилтийн хөтөлбөрийн дараах 8 зарчмуудыг удирдлага болгон баримтална:
 - 2.1.1. Байгаль орчноо хамгаалах - Бид хөрс, ус, агаар, биологийн олон янз байдал, байгалийн сэргээгдэх болон сэргээгдэхгүй шавхагдаж буй нөөцийг хадгалан хамгаалж, тэдгээрт үзүүлэх сөрөг нөлөөллийг бага байлгах аар тогтвортой ашиглах хандлагыг дэмжин ажиллана.
 - 2.1.2. Хүний эрх, нийгмийг хамгаалах - Бид хүний эрх, хөдөлмөрийн стандартыг хүндэтгэж, дэмжин, сурталчлах ба иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалж, тэдгээрийн тэгш, хүртээмжтэй байдлыг хангаж ажиллана.
 - 2.1.3. Соёлын өвийг хамгаалах - Бид Монгол Улсын түүхэн тодорхой орон зай, цаг үеийг төлөөлөх соёлын онцгой өв болох ёс заншил, хэл, бусад өв, түүнчлэн нийгэм, соёл, түүх, археологи, палеонтологийн түүх соёлын дурсгалыг хадгалж хамгаалан ажиллана.
 - 2.1.4. Ногоон эдийн засгийн өсөлтийг дэмжих - Бид Монгол Улсын эдийн засаг, ногоон шилжилтэд хувь нэмэр оруулах төсөл болон бусад үйл ажиллагааг дэмжин ажиллана.
 - 2.1.5. Санхүүгийн хүртээмжийг дэмжих - Бид эмэгтэйчүүд, эмзэг бүлгийн хүмүүст очих санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэн, санхүүгийн боловсрол олгох, харилцагчийг хамгаалах замаар Монгол Улсад санхүүгийн өргөн хүртээмжтэй тогтолцоог бий болгохыг дэмжин ажиллана.
 - 2.1.6. Ёс зүйтэй санхүүжилт, компанийн засаглалыг дэмжих - Бид хориглосон жагсаалтад багтсан үйл ажиллагааг санхүүжүүлэхгүй, бид ёс суртахуунгүй, гэмт хэргийн шинж чанартай үйлдлийг үл тэвчих бодлого явуулж, ёс зүйтэй байх, компанийн засаглалтай холбоотой сайн туршлагауудыг дэмжих.
 - 2.1.7. Ил тод байдал, хариуцлагатай байдлыг дэмжих - Бид ил тод байдал, хариуцлагатай байдлыг дэмжин, тогтвортой санхүүжилтийн үүрэг хариуцлагын хүрээнд тайлагнах явдлыг дэмжин ажиллана.
 - 2.1.8. Манлайлан үлгэрлэх - Бид Монгол Улсад байгаль орчин, нийгэм, эдийн засгийн эерэг хөгжлийг авчрахад шинэлэг санаачилга гарган, идэвхтэй ажиллана. Бид өөрсдийн



үлгэрлэн манлайллаараа харилцагчид болон салбартаа ижил жишиг тогтоохыг эрмэлзэнэ.

2.2. Компани нь НҮБ-ын тогтвортой хөгжлийн 17 зорилгуудыг удиртгал болгон боломжит 169 зорилтуудын хүрээнд хэрэгжүүлэх ажлуудыг жил бүрийн бизнес төлөвлөгөөтэй уялдуулан тусгайлан тодорхойлж, үйл ажиллагаандаа хэвшүүлж ажиллана. Үүнд:

Хүснэгт 1.

Д/д	Зорилгын нэр	Зорилт
1	Ядуурлыг устгах	7
2	Өлсгөлөнг зогсоох	8
3	Эрүүл мэндийг дэмжих	13
4	Чанартай боловсролыг дэмжих	10
5	Жендерийн тэгш байдлыг хангах	9
6	Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах	8
7	Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх	5
8	Зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлтийг дэмжих	12
9	Инновац болон дэд бүтцийг хөгжүүлэх	8
10	Тэгш бус байдлыг бууруулах	10
11	Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих	10
12	Хариуцлагатай хэрэглээг дэмжих	11
13	Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах	5
14	Далай, тэнгисийн нөөцийг хамгаалах	10
15	Хуурай газрын эко системийг хамгаалах	12
16	Энх тайван, шударга ёсыг цогцлоох	12
17	Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлэх	19

Гурав. БОНЗ-ын бодлогын зарчмуудыг хэрэгжүүлэх чиг үүрэг

- 3.1 Компанийн алба нэгжүүд нь БОНЗ-ын хүрээнд баримтлах зарчмуудыг хэрэгжүүлэхдээ гадаад болон дотоод үйл ажиллагаагаар дамжуулан хэрэгжүүлнэ.
- 3.2 Компанийн БОНЗ-ын ажлын багийг 5-аас доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэй байхаар ТУЗ эсвэл Гүйцэтгэх захирлын шийдвэрээр томилно.
- 3.3 Компанийн БОНЗ-ын ажлын баг нь жил бүрийн бизнес төлөвлөгөө боловсруулж батлуулах хугацаанд бусад алба нэгжүүдтэй хамтран, бизнес төлөвлөгөөний үндсэн чиглэлтэй уялдааг хангасан байдлаар дараа жилийн БОНЗ-ын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан ТУЗ-д танилцуулж батлуулна.
- 3.4 Тухайн оны БОНЗ-ын төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн ажлууд, хүрсэн үр дүнг хэмжих үзүүлэлт, нөлөөлөл гэх мэт холбогдох агуулгыг багтаасан Компанийн БОНЗ-ын тайланг БОНЗ-ын ажлын багаас дараа жилийн 01 сарын 10-ны дотор боловсруулж ТУЗ-д танилцуулна.
- 3.5 Компанийн БОНЗ-ын тайланг 1 дүгээр улиралдаа багтаан олон нийтэд нээлттэй байдлаар Компанийн вэбсайтад байршуулна.